**ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

**2023 оны 12 сарын 01**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв сая.төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго: 2020 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээний 37.84 хувийг орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангаж байсныг 2021 онд 40,23-аас доошгүй хувьд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2020 оноос ахиулан 2024 онд 294,221.45 сая төгрөгт хүргэх. | | | | | | | |
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| Зорилт 1 | Орон нутгийн хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээний 21 хувийг хангах | Хувийн хэвшил ОНТ УТ Төсөл хөтөлбөр | Хангамжийн хувь | 19,2 | 21 | Аймгийн нийт хүн ам буюу жишсэн дундаж хүн амд төмс 222 тн, хүнсний ногоо 179.5 тн тус тус хэрэгцээтэйгээс төмсний 15,1 хүнсний ногооны 4.9 хувийг, нийт 21 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангасан байна. | 100 |
| 1.1 | Төмс тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх | Хувийн хэвшил-20,0 ОНТ-15,0 УТ-10,0 Төсөл хөтөлбөр-14,5 | Тариалсан талбайн хэмжээ /га/ | 29,4 | 30,4 | Энэ онд нийт 29 га-д төмс тариалсан. | 0 |
| | | | Хураан авсан ургацын хэмжээ /Тн/ | 234,4 | 245 | 29 га талбайгаас 222 тн ургац хураан авсан. | |
| 1.2 | Хүнсний ногоо тариалсан талбай болон хураан авсан ургацын хэмжээг нэмэгдүүлэх | | Тариалсан талбайн хэмжээ /га/ | 21,5 | 22 | Энэ онд нийт 22,3 га-д хүнсний ногоо тариалсан. | 68.7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хураан авсан ургацын хэмжээ /тн/ | 176,2 | 185 | Нийт 179,5 тн ургац хураан авсан. | |
| 1.3 | Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд өөрийн орон нутагт жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх | УТ-250,0 сая | Шинээр нэмэгдүүлсэн талбай хэмжээ га | 71,3 | 76,3 | Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөн "Хүнсний хангамж аюулгүй байдал"-ын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас "Орон нутагт жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төв байгуулах тендер зарлаж, тус тендерийн гүйцэтгэгчээр шалгарсан ЭМ ЖИ ДИ" ХХК нь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрыг түшиглэн Жимс жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг 3 га талбайд байгуулж гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.Үүнд 1,5 метр өндөр төмөр хашаа 700 метр, техникийн нөхцөлийн дагуу цахилгаан эрчим хүчний хангамжийг хэвийн явуулах 1150м цахилгааны утас татаж, 40 см гүнд булсан байна. Мөн гүний худаг 1 ш, усны сав 20 тонн 1 ш, 120 м2 нийлэг хальсан хүлэмж 2 ш, 4х6 хэмжээтэй агуулахын байр, 3х8 хэмжээтэй зөөврийн орон сууц, мотоблок, анжис, роторт сийрүүлэгч, гар багаж хүрз 5 ш, секатор 2 ш, хайч 2 ш, өвс хадагч 1 ш /бензин мотортой/, улиас 175 ширхэг, хайлаас 700 ширхэг нийт 3 эгнээ 875 ширхэг хамгаалалтын ойн зурвас, 7 төрлийн жимс жимсгэнийн суулгац 1500 ширхэг, нийт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | модны талбайд дуслын усалгааны төхөөрөмжтэй холбогдсон. Нийт 2375 ш мод жимс, жимсгэнийн суулгацыг суулган хүлээлгэн өгсөн.<br>2023 онд шинээр 6,5 га-д тариалалт хийж, аймгийн хэмжээнд нийт жимс, жимсгэний талбай 77,8 га болж нэмэгдсэн. | |
| | | | Өмнөх оноос нэмэгдсэн ургацын хэмжээ тн | 4,5 | 5,5 | Жимс, жимсгэнэ 5,5 тн-ийг хураан авч өмнөх оноос хураан авсан ургац 1 тн нэмэгдсэн үзүүлэлттэй. | |
| Зорилт 2 | УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх | УТ 595,0сая, ОНТ-1,5сая Хувийн хэвшил - 255,0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 80 | УИХ-ын 2022 оны “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 84,4 хувьтай байна | 100 |
| 2.1 | Өвөл, хаврын улирлын хүн амын хэрэгцээний махны нөөцийг мөрдүүлж, махны хангамж үнийн тогтвортой байдлыг хангах | Хувийн хэвшил-604,0 сая | Нөөцөлсөн махны хэмжээ тн | 100 | 100 | Орон нутгийн хүн амын хавар зуны улирлын махны хэрэгцээг хангах, үнийг тогтвортой байлгах зорилгоор Сайнцагаан сумын махны худалдаа эрхлэгч ААНэгж “Номгон рашаан” ХХК, иргэн Дэмчигбаатар, Мөнхбат нар нийт -93,0 тн махыг зориулалтын хөргүүртэй агуулахад нөөцөлж хүн амын хэрэгцээнд нийлүүлж байна.<br>-Сайнцагаан сумын махны худалдаа эрхлэгч иргэн ААНэгжүүд стандартын шаардлага хангасан хөргүүртэй болон гүн хөлдөөх агуулахад 537,5 тн хонь ямааны махыг нөөцөлсөн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Хүнсний боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой явуулахад тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгийн зээлийн дэмжлэг үзүүлэх | УТ-595,0 сая.төг | Дэмжлэгт хамрагдсан үйлдвэр, цехийн тоо | - | 1 | ХХААХҮЯамнаас хэрэгжүүлж буй хүнсний үйлдвэрлэлийг дэмжих “Хөрөнгө оруулалт”-ын хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар Сайнцагаан, Говь-Угтаал сумын хүнс үйлдвэрлэгч 7 ААН хүсэлт ирүүлснийг ХХААХҮЯамны ХҮБХЗохицуулах газарт мэдээллийг хүргэж улмаар аймгийн арилжааны банкуудад үйлдвэрлэгчдийн мэдээлэл ирж зээл судлагдан, ХААН банкнаас Мандалговь Хүнс ХХК 245,0 сая, Жаргалант сор ХХК 320,0 сая, Хас банкнаас Элбэг Дэнж ХХК 30,0 нийт 3 ААН 595,0 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдан үйлдвэрлэлээ өргөтгөн ажиллаж байна. | 100 |
| 2.3 | Аймгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчдад олгож буй хоолны шим тэжээлийг тооцож, хоол хүнсний зохистой хэрэглээний нормд хүргэсэн байна. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд орон нутгаас нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлсэн байх | ОНТ-2,1 сая | Нийлүүлсэн бүтээгдэхүүний нэр төрөл тоо | 3 | 3 | Жайка Олон улсын байгууллагаас хэрэгжиж байгаа Үдийн хоолны загвар төсөлд сонгогдсон Мандал, Говийн Ирээдүй сургуулийн хоол, хүнсний хангамжид орон нутгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 10 иргэн Бууцай, чинжүү, хулуу сонгино зэрэг 7 нэр төрлийн 515 кг хүнсний ногоог, Мөн Сургууль цэцэрлэгийн хүүхдийн хоолны хангамжид Мандалговь хүнс, Говийн Гэгээ ХХК-иуд нь талх нарийн боов, Номгон рашаан, Их хайрхан мандал, Өнгүүр хадаа ХХК-иуд мах, сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлж байна.<br>Орон нутгийн үйлдвэрлэгч 18 иргэн ААНэгж 11 нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлж байна. | 100 |
| Зорилт 3 | Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарт дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, жижиг дунд, хөнгөн, хүнсний үйлдвэрийн | ЖДҮХС ан-269.5 сая.төг рөг | Үйлдвэрийн тоо | 51 | 53 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас Сайнцагаан сумын “Урам кидс” ХХК 90.0 сая төгрөгийн санхүүжилт авч оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг явуулж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо 2022 онд 51 байгааг 2023 онд 53 болгоно. | | | | | “Мөнгөлөг МД” ХХК өвлийн хүлэмж байгуулах зорилгоор 179.5 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байна. Барилгын явц 80 хувьтай байна.<br>Энэ онд шинээр 2 үйлдвэр байгуулагдсан. | |
| 3.1 | Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах борлуулалтын цэгийн орлогыг нэмэгдүүлэх | Хувийн хэвшил -571,3 сая.төг | Борлуулалтын орлогын өсөлт /Сая.төг/ | 142 | 150 | Орон нутгийн өмчит Дундговьд үйлдвэрлэв дэлгүүрээр 180 иргэн, ААНэгжийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. Энэ жилийн борлуулалтын орлого нь 348.0 сая төгрөг байна.<br>Мөн бизнес хөгжлийн төвд бойжиж буй 20 иргэн, ААНэгж нь нийт 223.3 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж байна.<br>Бизнес эрхлэгчдийг ажлын байртай болгож, үйл ажиллагааг тогтмолжуулж өгснөөр борлуулалтын орлого өмнөх оноос 220,0 сая төгрөгөөр өссөн. | 100 |
| 3.2 | Орон нутгийн онцлогтой хоршоодыг байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан сургалтын тоо | 2 | 2 | ХХААХҮЯамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийн газартай хамтран Бизнес эрхлэгч нарт хоршоо хөгжүүлэх сан болон хоршооны тухай ерөнхий ойлголт, хоршоо байгуулагдсанаар давуу талын талаарх сургалтыг 4 удаа 173 иргэнд зохион байгуулсан. Эрдэнэдалай сумын Далайн баялаг төгөл хоршоо нь Далайн шим болон Арвижих гэсэн 2 малчны бүлэгтэй. Бүлгүүд нь Хүнсний ногоо, сүү цагаан идээ, ногоон тэжээл тариалсан. Үүнээс Хүнсний ногоо болон Сүү, цагаан идээгээ борлуулан хоршооны дундын сандаа 3,0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4 | Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах | ОНТ- 1,400,0 сая | Өвөлжилтийн бэлтгэл хангасан хувь | 86,3 | 87 | Засгийн газрын 2023 оны 279 дугаар тогтоол, сумдын мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах шалгуур үзүүлэлт, аймгийн Засаг даргын 2023 оны А/459 дугаар захирамжийн дагуу аймгийн хэмжээний өвөлжилт, хаваржилтын бэлтгэл 88,2 хувьтай хангагдсан. | 100 |
| 4.1 | Тэжээлийн ургамал тариалах | ОНТ, Төсөл хөтөлбөр, Малчид сая/төг | Тариалах талбайн хэмжээ га | 12 | 7 | Дэлхийн зөн олон улсын байгууллага, малчдын хувийн хөрөнгө 101,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баянжаргалан, Гурвансайхан, Луус, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр сумдын малчид, Эрдэнэдалай сумын малчдын бүлэг 15,9 га бэлчээрийн талбайд тэжээлийн ургамал тариалж 15,8 тн ургац хураан авсан. | 100 |
| 4.2 | Бэлчээр хашиж хамгаалах | Малчид 1,134,0 сая/төг | Тухайн жилд хашсан талбайн хэмжээ га | 43,3 | 7 | Малчдын 1,134,0 сая төгрөгийн хувь хөрөнгөөр Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэрэн, Дэлгэрцогт, Луус, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдын 36 малчин өрх өвөлжөө, хаваржаагаа түшиглэн энэ онд шинээр 567 га бэлчээрийн талбайг хашиж хамгаалсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3 | Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулах. | УТ, ОНТ 167,0 сая төг | Тухайн жилийн тэмцсэн талбайн хэмжээ /мян га/. | 29,5 | 30,0 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тогтоол “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/143 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/218, А/587 дугаар захирамжийн дагуу Улсын төсвийн 167,0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан ,Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 10,0 мянган га бэлчээрийн талбайд микробиологийн аргаар, энгийн механик аргаар 30,0 мянган га бэлчээрийн талбайд, энэ онд нийт 40,0 мянган га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулсан. | 100 |
| Зорилт 5 | Бэлчээрийн усан хангамжийг өмнөх оноос нэмэгдүүлэх | УТ, ОНТ, Хувь сая. төг- 1396,1 | Бэлчээр усжуулалтын хувь | 1 | 0,2 | Улсын төсөв, орон нутгийн хөгжлиийн сан, малчдын хувь хөрнгө 1396,1 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр сумдад инженерийн хийцтэй 5 худаг, Дэлгэрхангай, Луус, Өлзийт сумдад инженерийн хийцтэй 13 худаг, Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумдад 30 цооног, Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай, Баянжаргалан сумдад 44 энгийн уурхайн худгийг сэргээн засварлаж нийт 72,0 мянган га бэлчээрийн талбайг усжуулж, өмнөх оноос 0,7 хувиар бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1 | Гүн өрмийн худгийг шинээр гаргах | УТ, ОНТ, малчид -1190,4 сая/ төг | Шинээр гаргасан худаг, цооног тоо | 52 | 15 | Улсын төсөв, орон нутгийн төсвийн 1190,4 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Луус ,Өлзийт сумд инженерийн хийцтэй 18 худаг, Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай сумд 30 цооног шинээр энэ онд нийт 48 худгийг шинээр гаргаж бэлчээр усжуулсан. | 100 |
| 5.2 | Энгийн уурхайн худгийг сэргээн засварлах. | ОНТ, Малчид -205,7 сая/төг | Засварласан худгийн тоо | 32 | 45 | Орон нутгийн төсөв, малчдын хувь хөрөнгө 205,7 сая төгрөгийн санхүүжилтээр Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Өлзийт, Сайнцагаан, Эрдэнэдалай, Баянжаргалан 8 сум 44 энгийн уурхайн худгийг сэргээн засварласан. | 92,3 |
| 5.3 | Булгийн эх хашиж хамгаалах | ОНХС- 20,0 сая, төг | Хашсан булгийн эхийн тоо | 3 | 1 | Орон нутгийн хөгжлийн сангийн 20, 0 сая төгрөгийн санхүүжилтээр Адаацаг сумын Баянхошуу, Хулд сумын Дал, Сайхан-Овоо сумын Дэлгэрэхийн булаг нийт 3 булгийн эхийг хашиж хамгаалсан. | 100 |
| Зорилт 6 | Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 700 малд шинээр нэвтрүүлж малын хаврын амьдын жинг 2-3 хувиар нэмэгдүүлнэ. | ОНТ, Хувь хэвшил- 3,5 сая төг | Тухайн жилд дэвшилтэт арга ашигласан малын тоо | 400 | 500 | Энэ онд 500 эм хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийсэн. Мөн битүү хөнгөлгөөний аргаар 250 хурга, 20 бяруун хөнгөлж аймгийн хэмжээнд нийт 770 малд биотехнологийн ололтыг нэвтрүүлсэн.<br>Битүү хөнгөлгөө, зохиомол хээлтүүлэг зэрэг биотехнологийн дэвшилтэт аргыг ашигласнаар малын амьдын жинг 3-6 кг буюу жингийн өсөлт 5-10 хувиар нэмэгдүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | Сайнцагаан омог, нутгийн монгол хонинд зохиомол хээлтүүлэг хийх, | ОНТ- 2,5 сая төг | Тухайн жилд хээлтүүлэг хийсэн малын тоо | 400 | 500 | Сайнцагаан омгийн хээлтэгчид, Сайнцагаан омгийн хээлтүүлэгчээр, нутгийн монгол хонинд, өндөр ашиг шимт суффолк үүлдрийн хээлтүүлэгчээс үр авч хээлтүүлэг хийсэн. Энэ онд 500 эм хонинд хээлтүүлэг хийж, аймгийн хэмжээнд нийт 1850 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдээд байна. | 100 |
| 6.2 | Баталгаажсан омгийн болон нутгийн малд үзлэг ангилалт хийх | УТ, ОНТ 25,0 сая, төг | Тухайн жилд ангилалтанд хамрагдсан малын тоо | 16000 | 4000 | Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 09 сарын А/473 тоот тушаалын дагуу баталгаажсан үүлдэр омгийн бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, ялган тэмдэгжүүлж, бүртгэлжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын 2023 оны 09 сарын 19-ны өдрийн А/531 тоот захирамжийн дагуу Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний 3-н нэгж, сумдын хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдтэй хамтран 12935, ухна 10543, нийт 23478 хээлтүүлэгчийг үзлэг ангилалт хамруулсан. | 100 |
| 6.3 | Битүү хөнгөлгөөний аргыг хэрэглэх | ОНТ, хувийн хөрөнгө 1,0 | Хөнгөлсөн малын тоо | 680 | 700 | Энэ онд битүү хөнгөлгөөний аргаар Сайнцагаан, Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Адаацаг сумдад хурга-250, бяруу-20 , нийт 270 малыг хөнгөлсөн. Аймгийн хэмжээнд нийт 950 малд битүү хөнгөлгөөний аргыг ашиглаад байна.<br>Битүү хөнгөлгөөний аргыг ашигласнаар малын амьдын жинг 3-6 кг буюу жингийн өсөлт 5-10 хувиар нэмэгдэж байна. | 100 |
| 6.4 | Өндөршил омгийн адуунаас үр авах | ОНТ- 3,0 | Авсан үр тун | 0 | 100 | Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран Өндөршил омгийн 2 азарганаас 300 тун үр авч генийн санд хадгалуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.5 | Өлзийт сумын нутгийн монгол улаан ямааг мэргэжлийн байгууллагатай хамтран судлах | ОНТ-20,0 | Судалгаанд хамрагдсан ямааны тоо | 0 | 5000 | ХХААГ, Өлзийт сумын ЗДТГазартай Төрийн соёрхолт, ямаа судлаач, доктор Б.Мандахаар ахлуулсан ажлын хэсэг хамтран Дэл уулын улаан ямааны ноолуурын судалгааны ажлыг хийсэн. 25 малчин өрхийн 1-4 насны 5000 ямааны ноолуурын гарц, дээж, хяналтын самналт, намрын амьдын жингийн дунджийг тооцсон. Судалгаанд хамрагдсан малчдад ноолуурын ямаан онцлог, сүргийн зохистой харьцаа, хээлтүүлэгч хэрхэн зөв сонгон тавих, ноолуурын микрон тодорхойлох болон ямааны аж ахуйн талаар сургалт, мэдээлэл өгч ажилласан. 2023 оны 07 сард Дэл уулын улаан ямааны генетик нөөцийг судлуулахаар 4-н өрхийн 30 ямааны чихнээс дээж авч, мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэнд хүргэсэн. | 100 |
| 6.6 | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах | ОНТ-30,00 | Стратеги төлөвлөгөө боловсруулсан тийм-1, үгүй-0 | 0 | 1 | Мал аж ахуйн дунд хугацааны 2024-2033 он хүртэл хэрэгжүүлэх 11 зорилт, 7-н бүлэг, арга хэмжээтэй мал аж ахуйн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 сарын 27-ны өдрийн 28 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж 2024 оноос эхлэн хэрэгжүүлж ажиллана. | 100 |
| 6.7 | Нийт үхэр сүргийг хавар, намрын технологит хугацаанд ялган тэмдэглэн ээмэгжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх | Хувь хөрөнгө -5,0 сая.төг | Ээмэгжүүлсэн үхрийн тоо | 363 | 100 | Говь-Угтаал- 24, Баянжаргалан 50 Дэлгэрхангай 45 сумд нийт 119 үхрийг ээмэгжүүлсэн. | 100 |
| | | 0 | Тухайн жилд бүртгэсэн үхрийн тоо | | 100 | Ялган тэмдэглэж, ээмэгжүүлсэн нийт 119 үхрийн мэдээллийг малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 100 хувь хамруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 7 | Хүнсний сүлжээний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулна. | 0 | Эрсдэл буурсан аж ахуйн нэгж иргэдийн тоо | 12 | 50 | Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 189 иргэн, аж ахуй нэгжийг хамруулан эрсдэлийг бууруулж, урьдчилан сэргийлж, хүнсний аюулгүй байдлыг ханган ажилласан. | 100 |
| 7.1 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, эрсдэлийг бууруулах | УТ-0,180сая | Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/ | 95.8 | 100 | Тайлант хугацаанд 1 иргэнээс ирсэн гомдол мэдээллийн дагуу 1 аж ахуй нэгжид төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 15 дутагдал илэрч, улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч дутагдлыг арилгуулсан. Шалгалтын үр дүнд зөрчил дутагдал арилгуулалт 80%, хууль сахин мөрдөлтийн хэрэгжилт 85%-тай болсон. Хяналт шалгалтаар хийгдсэн ажил, авсан арга хэмжээ, үр дүнг гомдол гаргагчид албан бичгээр өгч, танилцуулж ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100% | 100 |
| | | | Зөрчил арилгуулалт /хувь/ | 74 | 75 | | |
| | | | Хууль сахин мөрдөлтийн түвшин /хувь/ | 82 | 83 | | |
| 7.2 | Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 30 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | УТ-8,0 сая | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тооны өсөлт | 12 | 30 | Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 хяналтын чиглэлээр 60 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 6 объектын үйл ажиллагаа зогссон шалгалтыг хүнсний үйлдвэр 4, худалдааны 28, хоол үйлдвэрлэлийн 22, нийт 54 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн. Хяналт шалгалтаар эрсдэлийг үнэлэхэд 8 объект дунд, 46 обьект бага эрсдэлтэй үнэлэгдэж, давхардсан тоогоор нийт 461 дутагдал илрүүлж, хяналт шалгалтын явцад 23,2% буюу 107 дутагдлыг тухайн объект дээр нь арилгуулсан. Бусад дутагдлуудыг | 100 |
| | | | Хууль тогтоомжийн хэрэгжилт /хувь/ | 78,5 | 79 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эрсдэл үүсэх магадлалын бууралт /хувь/ | 18,3 | 17 | арилгуулахаар 354 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгсөн. Албан шаардлагын хэрэгжилт 86%-тай байна. Хууль тогтоомжийн хэрэгжилт 80,5%, эрсдэл үүсэх магадлал 19,4%-тай. Хяналт шалгатын явцад стандарт дүрэм журам мөрдөж ажиллаагүй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл хөтлөөгүй нэг иргэнд хялбаршуулсан журмаар Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 5.3 дахь заалтын дагуу 300000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллаа. Үр дүн: Хяналт шалгалтад хамрагдсан 46 объект буюу 85,1% нь эрсдэл буурсан байна. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар эрсдэл үүсэх магадлал 11,75%, Хууль тогтоомжийн хэрэгжилт 95,3% байна. Мал үржлийн хяналтын чиглэлээр их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 15 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж 14 их, 1 дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Гүйцэтгэлийн хяналтад 100% хамруулж 9 их, 4 дунд, 2 бага эрсдэлтэй болсон байна. Эрсдэл үүсэх магадлал дунджаар 17% буурсан, хууль тогтоомжийн хэрэгжилт 18%-иар нэмэгдсэн байна. Хяналт шалгалтаар нийт 198 зөрчил илэрснээс 148 зөрчлийг бүрэн арилгуулж, албан шаардлагын хэрэгжилт 94.6%-тай хэрэгжилтийг хангасан байна. | |
| | | | Албан шаардлагын хэрэгжилт /хувь/ | 94 | 95 | | |
| 7.3 | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох | УТ-3,0 сая | Урьдчилан сэргийлэх шалгалт /асуудлын тоо/ | 2 | 3 | Нийтийг хамарсан баяр ёслол, хүүхдийн зуслан, гадаад орны болон төр засгийн тэргүүн, тусгай хамгаалалт бүхий этгээд, зочин төлөөлөгчдийн айлчлалын үед | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зорилгоор урьдчилан сэргийлэх шалгалтыг хэрэгжүүлэх | | Сургалтын үр дүнгийн үнэлгээ /маш, сайн-4, дунд-3, муу-2, маш муу-1/ | - | 4 | хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар худалдааны 113, хоол үйлдвэрлэлийн 56, гурилан бүтээгдэхүүний үйлдвэр 5, нийт 159 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн.<br>Шалгалтаар бүтээгдэхүүний хадгалах горим, бүртгэл хөтөлгөөтэй холбоотой нийт 382 дутагдал илрүүлж, 97,8%-ийг тухайн газар дээр нь арилгуулж, 6 аж ахуй нэгжид 56 заалттай улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага өгч ажилласан. Албан шаардлагын хэрэгжилт 89%.<br>Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго, хүнсний нэмэлт, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацаа зэрэг 3 сэдвээр зөвлөмж гарын авлага хийж, 7 сумын аж ахуй нэгж, иргэдэд 80 ширхгийг түгээж, 54 газрын 104 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол” сэдвээр малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад оролцогч 149 хүнийг хамруулан сургалт зохион байгуулсан. Иргэдээс сургалтын талаарх сэтгэл ханамжийн судалгааг авахад 96,7% нь 4 буюу сайн гэж үнэлсэн байна.<br>Мал үржлийн хяналтын чиглэлээр Өвөлжилтийн бэлтгэл хангалт, микробиологийн аргаар бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх үйл ажиллагааг шалгах 2 урьдчилан сэргийлэхийн удирдамжийн хүрээнд 30 объектыг хамруулж 8 төрлийн 17 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 6-г арилгуулж, үлдсэн дутагдлыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арилгуулахаар байгууллагын даргын албан бичгээр 1, улсын байцаагчийн 1 нийт 2 зөвлөмжийг 16 объектод хүргүүлж биелэлтийг тооцож ажилласан. Хяналт шалгалтын явцад “Малын арчилгаа маллагаа, тэжээлийн хэрэгцээ шаардлагыг тооцох тухай”, “Микробиологийн болон энгийн механик аргаар оготнотой тэмцэх, үр дүнг тооцох, аюулгүй ажиллагааны тухай” 2 төрлийн сэдвээр 8 суманд 45 албан хаагчид, 615 малчдад мэдээ мэдээллийг өгч сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. Шалгалтыг товлосон хугацаанд нь хийж гүйцэтгэн холбогдох дээд шатны байгууллагад мэдээллийг хүргэн ажилласан. | |
| 7.4 | Баталгаажуулах үйл ажиллагааг 3 хийх | УТ-0,3 сая | Баталгаажуулалтад хамрагдсан иргэн, ААНБ-ын тоо | 2 | 3 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-02/28 дугаартай удирдамжийн хүрээнд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15'.1.3 дахь хэсэг, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд болон холбогдох стандарт, журам, дүрмийн хэрэгжилтийн байдалд 8 аж ахуй нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, ажлын байрны улсын байцаагчийн 8 дүгнэлт гаргаж ажилласан. | 100 |
| 7.5 | Шинэчлэн гарах, нэмэлт өөрчлөлт оруулах салбарын | | Өгсөн саналын тоо | 5 | 6 | 1. “Стандарт ба хөгжил” үндэсний хөтөлбөрийн төсөлд 3 санал. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль тогтоомж, дүрэм журам, стандартад санал өгөх | 0 | | | | 2. MNS ISO 22003-2:2023, "Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээ болон хүнсний аюулгүй байдлын тогтолцооны аудит хийх, үнэлж, баталгаажуулах байгууллагад тавих шаардлага" стандартын төсөлд 1 санал нийт<br>Согтууруулах ундаа худалдах худалдааны газрын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас 1 санал<br>4. 5021 ; 2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээний стандартад 2023.06.02 нэмэлт оруулсан төслүүдийн 5 заалтад санал<br>5.Мал үржлийн чиглэлээр “Үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ны 37-д Ургамал хамгааллын тухай хуулийн хүрээнд 1 санал<br>6.Өвс.Техникийн шаардлага MNS 0595;2008 стандартыг шинэчлэн батлах тухай нийт 6 чиглэлээр 11 саналыг ХХААХҮЯаманд хүргэсэн. | 100 |
| **ХОЁР.ХУУЛИАР ОЛГОГДСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| Зорилт 1 | Хүнс, хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх | ОНТ-4,0 | Мэргэжлийн боловсон хүчний хангалтын хувь | 47 | 50 | ХХААСалбарын мэргэжилтэн боловсон хүчин 58 байхаас 33 албан хаагч ажиллаж, 2 суманд 2 мэргэжилтэн шинээр ажилд орж боловсон хүчний хангамж 56,8 хувьтай байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 0 | 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж буй төрийн албан хаагчдын тоо | 23 | 26 | ХХААГазарт 13, сумдын ХААТасагт 15 албан хаагч, нийт 28 албан хаагч 3-аас дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа нь хөдөө аж ахуйн салбарт одоо ажиллаж байгаа нийт албан хаагчийн 70 хувийг эзэлж байна. | 100 |
| 1.1 | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | УТ-2,5 сая | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 95 | 95 | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны 4 зорилт 11 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан. | 100 |
| 1.2 | Хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинээр ажиллагсадыг ажлын байранд дадлагажуулах | 0 | Хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 2 | Цагаандэлгэр сумын ХААТасгийн 1 мэргэжилтэн, ХААИС-ийн Зоо-инженер технологийн ангийг төгссөн 1 шинэ мэргэжилтэнг мал, ангилалт, ээмэгжүүлэлт бүртгэлжүүлэлтийн чиглэлээр ХХААГ-ын мэргэжилтнүүд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч , арга зүй, удирдлагаар хангаж, ажлын байранд дадлагажуулан ажилласан. Төрийн албаны шалгалтад тэнцэн ажиллахаар болоод байна. | 100 |
| Зорилт 2 | Авилгаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх | 0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн Хувь | 100 | 100 | Авлигаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн 5 зорилт бүхий 16 заалт бүхийн төлөвлөгөөг ХХААГ-ын даргаар батлуулж жилийн эцсийн хэрэгжилт 100 % хэрэгжсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах”Шударга ёс-Хөгжил дэвшилд хамтдаа” аян зохион байгуулах | 0,05 мян.төг | Аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 100 | “Шударга ёс-Хөгжил дэвшилд хамтдаа” аяныг 06 сарын 03 өдрөөс 06 сарын 10 өдрийн хугацаанд байгууллага дээр зохион байгуулж, аяны хүрээнд хэрэгжүүлэх 8 заалт бүхий төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаа. Аяны дэвтэр, тугийг хуваарийн дагуу дараагийн байгууллагад хүргэж өгсөн. Авлигын эсрэг арга хэмжээг сурталчилсан гарын авлага материалыг Хүнс, хоол, худалдаа үйлчилгээний газар болон жижиг дунд үйлдвэр эрхлэгч 50 ААНБ, иргэдэд мэдээлэл өгч, ажлын байрны мэдээллийн самбарт мэдээллийг байршуулан үйлчлүүлэгчид мэдээлэл хүргэн ажиллаж байна. | 100 |
| 2.2 | Удирдах албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн судалгааг гаргаж ил тод мэдээлэх | 0 | Мэдээлсэн тоо | 2 | 2 | Тус байгууллагын удирдах болон нийтийн албан тушаалтан 7 албан хаагчийн 17 хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн судалгааг авч нэгтгэн байгууллагын ил тод болон мэдээллийн самбарт мэдээлсэн. | 100 |
| 2.3 | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг сахин мөрдөж ажиллах | 0 | Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2023 оны А/03 тоот тушаалаар байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчлэн томилсон. Ёс зүйн зөвлөл нь энэ онд нийт 10 ажлыг төлөвлөн 100 хувь хэрэгжүүлэн ажилласан. | 100 |
| **ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| Зорилт 1 | Тариалан эрхлэгч нарт хөнгөлөлттэй үрийг нийлүүлнэ | | Хүнсний ногооны үрийн нэр, төрөл | 2 | 2 | Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас хаврын тариалалтад зориулан олгож буй хүнсний ногооны 13 нэр төрлийн 80 хувийн хөнгөлөлттэй 2.5 тн, 9,422, 925 | 100 |
| | | | Олгосон үрийн хэмжээ/кг/ | 2600 | 150 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | УТ-9.4 | | | | төгрөгийн үрийг татан авч, 15 сумдад хуваарилан тараан олгож тариалалтыг дэмжин ажилласан. | |
| | | | Мөнгөн дүн /сая.төг/ | 3.1 | 1,5 | | |
| 1.1 | Тариалан эрхлэгч нарт технологийн сургалт зохион байгуулах | Төсөл хөтөлбөр - 14,5 ОНТ- 3,2 | Сургалтын тоо | 3 | 3 | 1. "Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Судалгаа хөгжлийн төв", Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/- тай байгууллагатай хамтран төмс, хүнсний ногооны дэмжих "SHEP" хөтөлбөрийн хүрээнд "Хүнсний ногоог хэрхэн өргөжүүлэн хөгжүүлэх", "Хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх","Газар тариалангийн цахим систем бүртгэх", урамшуулалд хамрагдах сэдэвт сургалтыг 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр зохион байгуулсан. Тус сургалтад 13 сумаас хүнсний ногоо тариалах сонирхолтой 60 тариалан эрхлэгч хамрагдсан байна.<br><br>2. "Ногоон-Ази" ТББ-тай хамтран "Дэлхийн ойн өдөр"-ийг угтаж мод тарих, арчлах, мод үржүүлгийг үр болон модожсон мөчрөөр үржүүлэх, өвчин хортонтой тэмцэх, нарийн ногоо тарих, дуслын усалгааны системийн ач холбогдол, угсралт холболт хийх сургалтыг Хот тохижуулах газрын албан хаагчид болон иргэд нийт 50 хүнийг хамруулсан.<br><br>3. "Дундговио ногооруулъя " хөтөлбөрийн хүрээнд " Алимын мод тарих сургалт"-ыг Политехникийн коллеж, БОАЖГ, ХХААГ хамтран 140 тариалан эрхлэгчид зохион | 100 |
| | | | Хамрагдсан иргэдийн тоо | 110 | 60 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан.<br><br>4. Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих" төслийн нэгжтэй хамтран Сайнцагаан сумаас сонгогдсон “Мандал”, “Говийн Ирээдүй” сургуулийн үдийн хоолны хангамжид төмс, хүнсний ногоо нийлүүлэх 10 ногоочин сонгож, хаврын тариалалтад зориулан нэн шаардлагатай үр болон гар багаж, хүлэмжийн тоног төхөөрөмж нийт 11.0 сая төгрөгийн үнэ бүхий багажийг хүлээлгэн өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тус 10 ногоочинд төмс, хүнсний ногоо нийлүүлэх танхимын болон талбайн үзүүлэх сургалтыг ахмад агрономич Н.Цэнд-Аюуш, ногоочин Р.Мужил багш нар удирдан явуулж хамтран ажиллав.<br><br>5.“Каритас Монгол байгууллагатай хамтран “Нарны эрчим хүчээр ажиллах хүлэмжийн онцлог, ажиллуулах, арчлах арга”, "Байгал орчныг хамгаалахад хүний хүчин зүйлийн нөлөө” "Чийгийн улаан хорхой үржүүлэх, гэрийн нөхцөлд био ялзмаг бордоо гарган авах" сэдэвт сургалтыг 2023 оны 3 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан Уг сургалтад төмс, хүнсний ногоо тариалах сонирхолтой 30 тариалан эрхлэгч хамрагдсан байна.<br><br>6. Дундговь аймгийн Засаг даргын Тамгын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газар, МОРА ТББ болон МОРА ЖИ ЭЙ групптэй хамтран “Хүнс хөдөө аж ахуй, хүнсний ногоо, хүлэмжийн бизнесийн ирээдүйн чиг хандлага, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх гарц – Япон орны туршлагаас” сэдэвт сургалт, санал солилцох уулзалтыг есдүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, сумдын хөдөө аж ахуй, газар тариалан, хариуцсан мэргэжилтэн, 45 газар тариалан эрхлэгч 45 иргэнийг хамруулсан.Түүнчлэн шинэ сорт болох шар тарвас, торлог амтат гуаны туршилтын тариалалтыг өвлийн Нарлаг хүлэмжид хийхээр лабораторийн шинжилгээнд хамрагдаж, чанарын шаардлага хангасан үрийг өгөхөөр болжээ. Мөн хөрс сайжруулах ургамлын тариалалтыг Луус суманд туршихаар болсон байна.<br><br>Төсөл хөтөлбөр, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран 6 удаагийн сургалтад 335 иргэнийг хамруулж ногоо тарих арга технологид суралцуулж, шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг олгон нийт 18,6 сая төгрөгийг зарцуулсан байна. | |
| 1.2 | Хөдөө аж ахуйг дэмжих сангаас авсан техник тоног төхөөрөмжийн энэ оны хувиарт төлөлтийг барагдуулах | Хувийн хэвшил -1,2 | Тухайн жилийн төлөгдөх мөнгөн дүн | 1,2 сая.төг | 0,9 сая. төг | Энэ онд Сайнцагаан , Дэлгэрцогт, Луус, сумдын 6 иргэн гэрээний дагуу төлөгдөх зээлийн төлбөр 1 221 383 төгрөгийг ХААДСанд төвлөрүүлж, эргэн төлөлт 100 хувь төвлөрүүлэн ажилласан. | 100 |
| | | | Иргэний тоо | 7 | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 2 | Монгол үндэсний уламжлалт (орон нутгийн онцлогтой) хоол, идээ ундааг хөгжүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр ажлуудыг хийх | ОНТ-1,4сая<br><br>Хувийн хэвшил-1,0 сая | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 3 | "Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд “Зүүн болон Говийн бүсийн Аварга тогооч, зөөгч шалгаруулах сургалт, ажил мэргэжлийн уралдаан" тэмцээн Сүхбаатар аймагт 2023 оны 3 дугаар сард зохион байгуулагдсан. “Гран при”, Зоогийн газар, кафе, “хүүхдийн хоол”, "Эмнэл зүй" “Оюутан” зэрэг 5 төрөлд манай аймгийн сургууль, цэцэрлэг, хувийн хэвшлийн нийт 9 тогооч оролцлоо. 7 аймгийн 150 гаруй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид сургалтад хамрагдаж, ур чадвараараа өрсөлдөж "Хүүхдийн хоолны" төрөлд Сайнцагаан сумын Мандал сургуулийн тогооч А. Отгонцэцэг, 5 дугаар цэцэрлэгийн ахлах тогооч Ш.Өлзиймаа нар "Дэд" байр, 8 дугаар цэцэрлэгийн ахлах тогооч О.Отончимэг, "Гутгаар" байр, "Оюутан" төрөлд Политехникийн коллежийн оюутан А.Батдэлгэр, Б.Цэрэнчунт нар "Гутгаар" байр эзэлж багаараа 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж амжилттай оролцлоо.<br>- Хүүхдийн шим тэжээлт хоол сэдэвт ур чадварын уралдааныг холбогдох газруудтай хамтран сургууль, цэцэрлэгийн тогооч нарын дунд 5 дугаар сард зохион байгуулсан. Тус уралдаан нь сургууль цэцэрлэгийн нэг өдрийн хоолны шим тэжээл, илчлэг хэмжээг хангасан хоол, ундааны багц шалгаруулж, шалгарсан хоолыг түгээн дэлгэрүүлэх сургууль цэцэрлэгийн хоолны цэсэд оруулах зорилготой дээрх уралдаанд 15 сумын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургууль, цэцэрлэгийн 40 гаруй тогооч оролцсон.<br>- Дундговь Түншлэл 2023 арга хэмжээнд оролцогч хоол үйлдвэрлэгчдийн дунд орон нутгийн онцлогтой хоол, идээ ундааг сурталчлах үзэсгэлэнг зохион байгуулсан. 6 иргэн, ААНэгж оролцсоноос “Өргөө” зоогийн газрын орон нутгийн онцлог бүхий уламжлалт хоол хүнс, шалгарсан байна. Нийт 3 арга хэмжээг зохион байгуулсан | |
| 2.1 | Хүнсний зориулалтын агуулах, зоорь, тусгай тээврийн хэрэгсэл, хүнсний түүхий эд бүтээгдэхүүний лабораторийг бүртгэж, ашиглалтыг сайжруулах | УТ, ОНТ Хувийн хэвшил | Бүртгэлд хамрагдсан агуулах зоорь, тээврийн хэрэгсэл, лабораторийн тоо | Агуулах зоорь 10 Лаб-2 Машин-8 | Агуулах зоорь 15 Лаб-2 Машин-10 | -Махны зориулалтын хөргүүртэй болон гүн хөлдөөгч зоорь, агуулахын нийт тоо 18 байгаагаас 0,3-8 тн багтаамжтай-7, 10-50 тн багтаамжтай -8, 80-100 тн багтаамжтай 3 агуулах байна.<br>Стандарт хэмжил зүйн хэлтсийн Сорилтын итгэмжлэгдсэн лаборатори, МЭАЦЛаборатори, Мандалговь Хүнс ХХК-ны дотоод хяналтын лаборатори, гэсэн 3 лабортаторт хүнсний түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтүүдийг шинжилж дүгнэлт гарган ажиллаж байна.<br>-Аймгийн хэмжээнд байгаа хүнсний зориулалтын тээврийн хэрэгслийн судалгааг авч нэгтгэн ХХААХҮЯамны ХҮБХЗГазрын Худалдаа, нийтийн хоолны хэлтэст хүргүүлсэн. зориулалтын тээврийн хэрэгсэл 12 байгаагаас 1-10 тн 5, 20-оос дээш тонн багтаамжтай 7 байна | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | Өвлийн идэш арга хэмжээг зохион байгуулах | Хувийн хэвшил -1,2 тэр бум төг | Борлуулсан махны хэмжээ тн | - | 150 | ХХААХҮЯам, аймгийн ХХААГ-тай хамтран зохион байгуулж буй өвлийн идэш арга хэмжээнд тус аймгаас 12 сумын 40 малчин 152 тн мах худалдан борлуулаад байна. Дээрх арга хэмжээ нь "Төв цэнгэлдэх", "7-н буудал", "Лавай" худалдааны төвүүдэд 11 сарын 27 өдрөөс 12 сарын 3-ныг хүртэл зохион байгуулагдана. | 100 |
| Зорилт 3 | Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх | ЖДҮХС ан-269.5 сая.төг рөг | Иргэн ААНэгжийн тоо | 54 | 59 | 2023 онд ЖДҮХСангаас 11 ААНэгжид 1,199,400,000 төгрөг олгосон ба үүний үр дүнд ЖДҮйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн тоо өмнөх оноос 11 нэмэгдэж 65 болсон. Хадгалагдсан ажлын байр-21, шинээр бий болсон ажлын байр-22 | 100 |
| 3.1 | Жижиг дунд бизнес эрхлэгчдэд салбарын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах. | -- | Иргэн ААНэгжийн тоо | 45 | 50 | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нарт зөвлөгөө, мэдээлэл өгөх, хууль тогтоомж, дүрэм журмыг сурталчлах санхүүгийн мэдлэг олгох сургалтыг Жижиг дунд үйлдвэрийн газар болон Монгол банк, ЖАЙКА, Азийн хөгжлийн банк, Зах зээл ба бэлчээрийн удирдлага төсөл, Зээлийн батлан даалтын сантай хамтран 3 удаа зохион байгуулж нийт 203 иргэнийг хамруулсан. | 100 |
| 3.2 | “Дундговь түншлэл 2023” үзэсгэлэн худалдааг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах | УТ, ОНТ, Хувийн хэвшил -2,9 сая.төг | Оролцогчдын тоо | 95 | 100 | 9 сарын 21, 22-ны өдрүүдэд болсон “Дундговь түншлэл - 2023” үзэсгэлэн худалдаанд 14 сумын 102 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч оролцож, хоёр өдрийн турш 87 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үзэсгэлэн худалдааны үеэр аймгийн онцлох, шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг шалгаруулсан Үүнд: Шилдэг зохион байгуулалттай сум: -Дэлгэрцогт сум Шилдгийн шилдэг гран при | 100 |
| | | | Борлуулалтын орлого | 72,9 | 85 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Ш.Бөндөгхорол /Эрдэнэдалай сум/ Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүн - С.Дэлгэржаргал /Луус сум/ - Д.Батцэцэг /Дэрэн сум/, - М.Намсрай /Гурвансайхан сум/ - Ж.Батсайхан /Адаацаг сум/ Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн - Д.Тунгалаг /Сайнцагаан/ - Б.Цэндмаа /Баянжаргалан сум/ Шилдэг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн - “Урам Кидс” ХХК /Сайнцагаан сум/ Шилдэг гар урлалын бүтээгдэхүүн - Ц.Баатар /Сайнцагаан сум/ Шилдэг орон нутгийн онцлогтой нийтийн хоолны үйлдвэрлэл - “Ээлт бор хайрхан” ХХК /Сайнцагаан сум/ Шилдэг хүнсний бүтээгдэхүүн - “Анар Ивээл” ХХК /Эрдэнэдалай сум/ тус тус шалгарсан. | |
| 3.3 | Сумдад явуулын ахуй үйлчилгээ үзүүлэх. | ОНТ-60,0 мянган. төг | Үйлчилгээ авсан иргэдийн тоо | 110 | - | Ахуй үйлчилгээний салбарт 173 иргэн, ААНэгж 238 иргэнийг ажлын байраар ханган үйл ажиллагаа явуулж байна. Явуулын ахуйн үйлчилгээ шаардлагатай сумдын судалгааг авсны дагуу 6 дугаар сарын 15-16-ны өдөр Дэрэн сумын ард иргэдэд үзүүлсэн. Ахуй үйлчилгээг дараах салбараар үйлчилгээ үзүүллээ. Үүнд: - Оёдол засвар - Гутал засвар - Үсчин - Гоо сайхан - Хумс, засал - Утас засвар Нийт давхардсан тоогоор 120 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлж 2,1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. | 100 |
| | | | Борлуулалтын орлого /сая,төг/ | 1,7 | 2,0 | | |
| Зорилт 4 | Мал аж ахуйн уламжлалт өв соёл,мэдээллийг түгээн дэлгэрүүлэх | ОНТ-5,0 сая | Аян зохион байгуулсан эсэх Тийм-1, үгүй-0 | 0 | 1 | Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 03 сарын А/59 тоот тушаалын дагуу “Малчдыг дэмжих анх дугаар аян” хүрээнд мал аж ахуйн салбарыг олон нийтэд сурталчлан таниулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чиглэлээр Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран өндөршил омгийн адуу, Сайнцагаан омгийн хонь, Олдохын хүрэн бор омгийн тэмээн, Улсын хошой аварга малчин,Улсын аварга малчин,айраг, адууны эвент арга хэмжээний талаарх хөрөг нэвтрүүлгүүдийг хийлгүүлж үндэсний телевизээр цацаж олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан . Өлзийт, Луус, Баянжаргалан, Говь-Угтаал сумдын малчдын зөвлөгөөнд мал аж ахуйн талаарх мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан. | |
| | | | Хамрагдсан малчдын тоо | 0 | 1200 | Уламжлал мал аж ахуйг түгээн дэлгэрүүлэх болон мал аж ахуйн чиглэл, бэлчээр, тэжээлийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн. энэ онд 6-н арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор нийтдээ 3510 малчинд мэдээлэл хүргэж ажилласан | 100 |
| 4.1 | "Тэмээчдийн баяр"-ыг зохион байгуулах | ТББ, ОНТ - 10,0сая | Зохион байгуулагдсан эсэх Тийм-1 Үгүй-0 | 1 | 1 | АЗДТГ, ХХААГ, Хулд сумын ЗДТГ хамтран 2023 оны 01 дүгээр сарын 26 өдөр “Тэмээний өв соёл эвент” арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж шилмэл тормон тэмээ, тайлган тэмээ, ойрын зайны буухиа уралдаан, сайхан буур, ингэ, ганган хос, сүүтэй ингэ, буйл зорох, бурантаг томох, тэмээний сүү, ноосон бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Арга хэмжээнд Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо, Манлай сумд, Дэлгэрхангай, Өлзийт сумдын тэмээчид оролцсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2 | Нутгийн айрганд лабораторын задлан шинжилгээний судалгааны ажил хийх | ОН Төсөл хөтөлбөр -30,0 сая | Судалгаа хийгдсэн эсэх Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | Өвөр монголын өөртөө засах орны хөдөө аж ахуйн ажил мэргэжлийн дээд сургуулийн эрдэмтэд, ШУТИС-ийн багш нартай хамтран Дэрэн, Адаацаг, Дэлгэрцогт сумдын малчдаар явж саам болон айргийн дээжийг зун, намар 2 удаа Өвөр монголын хөдөө аж ахуйн лабораторит хүргүүлж судалгаа хийгдэж байна. | 100 |
| 4.3 | Малчдыг чадавхижуулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх | Төсөл хөтөлбөр 79,9 сая | Хэрэгжсэн төслийн тоо | 0 | 1 | Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтэд тэсвэртэй орон нутаг төслийн 79,9 сая төгрөгийн санхүүжилтээр Эрдэнэдалай сумын Далайн шим малчдын бүлэг талбайн болон танхимын сургалтад хамрагдаж, 5га талбайг хашаалж, туршилтаар 2 га талбайд тэжээлийн ургамал тариалж 2,5тн ургац хураан авч тэжээлийн ургамал тариалах чиглэлээр чадавхжаад байна. | 100 |
| Зорилт 5 | Байгууллагын үйл ажиллагааг захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах | Улдсын төсөв-12,9 | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 | 4 | Байгууллагын албан хаагчдын дунд улирал бүр чөлөөт цагийг боловсон өнгөрүүлэх, авьяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр спорт, урлаг, ур чадвар сорьсон арга хэмжээнүүд болон хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26,2 дахь заалтад тусгагдсаны дагуу тус байгууллагын нийт төсвийн 0,5 хувь буюу 3,5 сая төгрөгийг албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдах үйл ажиллагаанд зарцуулан ажилласан. Нийт 8 арга хэмжээ зохион байгуулсан байна. | 100 |
| 5.1 | Албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлж байгууллагын дотоод сургалтыг тогтмолжуулах | БТ-0,4 | Зохион байгуулсан сургалтын тоо | 22 | 26 | Байгууллагын дотоод сургалтыг төлөвлөгөөний дагуу 14-н албан хаагч , шинээр батлагдан мөрдөж буй хууль, ЗГ-ын тогтоол, дүрэм журам,болон бусад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдолтой 17 сэдвийн хүрээнд давхардсан тоогоор нийт 28 удаагийн сургалт хийсэн. 17 албан хаагчийн сургалтад давхардсан тоогоор 215 ажилтан хамрагдсан. | |
| 5.2 | Байгууллагын цахим хуудсыг идэвхжүүлж, аймаг орон нутгийн болоод салбарын цаг үеийн мэдээллийг олон нийтэд хүргэх. | 0 | Мэдээний тоо | 63 | 64 | Байгууллагын ил тод, facebook page цахим хуудсанд салбарын болоод цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна. Нийт 68 мэдээ, мэдээллийг цахим хуудсандаа байршуулан ажилласан. | 100 |
| 5.3 | Албан хэргийг хос бичгээр хөтлөх ажлыг турших | 0 | Хэрэгжилтийн тайланг БШУГ-т хүргүүлэх тоо / сар бүр/ | 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн | 5 | Монгол хэл Уран зохиолын ахмад багш Уранбайгалтай гэрээ байгуулж албан хаагч нарыг дунд шатны сургалтад хамруулсан. Явцын тайланг холбогдох хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны газарт 3 удаа, явцын судалгааг 2 удаа нийт 5 удаагийн мэдээг хүргэсэн. Сургалтад нийт 19 албан хаагч хамрагдсан. Байгууллагын архив бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн архив албан хэрэг хөтлөлтийн чадавхжуулах чиглэлээр зохион байгуулагдсан төлбөртэй сургалтад хамрагдсан. | 100 |
| | | | Туршсан эсэх тийм -1, үгүй -0 | 0 | 1 | Хос бичгээр туршин 5-н суманд цаг үеийн асуудлын тухай албан бичиг хүргүүлсэн. | |
| Зорилт 6 | Байгууллагын гадна орчин өнгө үзэмжийг сайжруулан ая тухтай ажиллах нөхцөлийг хангах | Төсөл хөтөлбөр-12,5 сая.төг | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ сая.төг | 25,9 | 10,0 | Албан хаагчдын ая тухтай ажиллах боломжийг бүрдүүлэн байгууллагын дотоод өнгө үзэмж сайжруулах, засвар үйлчилгээнд-12,1 сая, албан хаагчдын танилцуулга, гамшгаас хамгаалах галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан самбар таних | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэмдгийг шинээр хийж- 450,0 мян.төг нийт 12,550,0 төгрөгийг зарцуулсан. | |
| 6.1 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган ажиллах | 0 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх 4 заалт бүхий төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг 100 % ханган ажилласан байна. Мөн ХХААХҮЯамнаас хэрэгжүүлсэн жимс, жимсгэнийн мод үржүүлгийн талбайд хайлаас модны суулгац тарьж хуваарын дагуу усалгааг хийж ажилласан. | 100 |
| 6.2 | Хог хаягдлаа ангилан ялгах | 0 | Ангилан ялгасан эсэх Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | Орон нутгийн үйлдвэрлэгчээс зориулалтын ангилан ялгах хогийн савыг худалдан авч байгууллагын хашаанд байршуулан байгууллагаас гарсан хогийг ангилан ялгаж байна. | 100 |
| 6.3 | Байгууллагад засвар тохижилтын ажлыг гүйцэтгэх | 12,1 сая | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ сая.төг | 26,3 | 10,0 | Албан хаагчдын ая тухтай ажиллах боломжийг бүрдүүлж, байгууллагын өнгө үзэмж сайжруулах засвар үйлчилгээнд - 12,1 сая төгрөг зарцуулсан. | 100 |
| Зорилт 7 | Гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалтын мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах | БТ-0 | Бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан эсэх Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | Газрын даргын 2023 оны А/04 дугаар тушаалаар Гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах хүнс, хөдөө аж ахуйн гамшгаас хамгаалах алба, тусгай зориулалтын мэргэжлийн ангийг 12 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. | 100 |
| 7.1 | Хүнс, хөдөө аж ахуйн албаны гамшигаас хамгаалах | 0 | Шинэчилсэн эсэх Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | Хүнс, хөдөө аж ахуйн албаны гамшгаас хамгаалах ажлын төлөвлөгөөг 16 чиглэлийн хүрээнд боловсруулан батлуулж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулах | | | | | хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөг аймгийн онцгой байдлын газрын төлөвлөгөөтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 7.2 | Албан хаагчдыг бүрэн хамруулж бэлэн байдлыг ханган ажиллах | 0 | Хамрагдсан эсэх<br>Тийм-1<br>Үгүй-0 | 0 | 1 | Онцгой байдлын ерөнхий газраас 09 сард тус аймагт гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан. Хүнс хөдөө аж ахуйн газар "Хүнсээр хангах алба" мэргэжлийн анги 12 хүний бие, бүрэлдэхүүн гамшгаас хамгаалах албаны бэлтгэл бэлэн байдлыг ханган оролцсон. | 100 |
| Зорилт 8 | Цахим системийн ашиглалтыг нэмэгдүүлэх | 0 | Нэвтрүүлсэн цахим арга хэмжээнүүдийн тоо | 0 | 1 | ХХААХҮЯ-аас Гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн санг ашиглалтанд оруулан албан хаагчид болон нэгж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг журмын хугацаагаар тайлагнаж хэвшсэн.<br>Ирсэн явсан бичиг, өргөдөл гомдол, хүний нөөцийн үйл ажиллагаа,үүрэг даалгавар албан хаагчдын ирцийн бүртгэлүүд erp сүлжээнд бүрэн цахимжиж албан хаагчид 100 хувь хамрагдаж байна. Байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичгийн үйл ажиллагаа erp, DOCX токен цахим систем дээр бүрэн цахимжуулсан. Байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичгийн үйл ажиллагаа erp цахим систем дээр бүрэн цахимжсан. Мөн байгууллагын даргын тоон гарын үсгийг баталгаажуулан суулгаж цахим албан бичгийг явуулж байна. Байгууллага болон албадын дарга нар албан хаагчдад ERP цахимаар нийт 22 үүрэг даалгавар өгч холбогдох албан хаагч нар 100 % хувь хэрэгжүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллагын хэмжээнд 4 салбарын хүрээнд 9 албан хаагч 18 цахим системийг нэвтрүүлж ашиглаж байна | |
| 8.1 | Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх | 0 | Нэгдсэн системийг нэвтрүүлсэн эсэх тийм-1 үгүй-0 | 0 | 1 | ХХААХҮЯ-аас Гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн системийг ашиглалтад оруулж албан хаагчид болон нэгж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг журмын хугацаагаар 100 хувь тайлагнаж хэвшсэн. | 100 |
| 8.2 | E-mongolia системийг иргэдэд сурталчилж төрийн үйлчилгээг үзүүлэх | 0 | Хамрагдсан иргэдийн тоо | 13 | 15 | E-mongolia цахим системийг байгууллагын ажилчид 100 хувь гар утсан дээрээ суулган цахим мэдээлэл болон төрийн үйлчилгээг цахимаар авч байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан болон хоршоо хөгжүүлэх сангаас зээл хүсэж буй иргэн ААН зээлтэй холбогдолтой тодорхойлолтуудыг e-mongolia системээс 38 аж ахуй нэгж хамрагдаж үйлчилгээ авсан.<br>Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан давтамжит сургалтуудад албан хаагч нар бүрэн хамрагдсан., Цахим системийг ашиглан жолооны үнэмлэх, гадаад паспорт цахимаар захиалах жолоодох эрхийн лавлагаа, тээврийн хэрэгслийн татвар, торгууль, газрын төлбөр,жолооны үнэмлэх шинээр авах зэрэг үйлчилгээг 100 хувь ашиглаж байна.<br>Цахим гарын үсгийг бүх албан хаагчид ашиглаж байна. | 100 |
| 8.3 | Албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны үйл ажиллагааг 100 хувь цахимжуулах | 0 | Цахимжуулсан эсэх<br>Тийм-1<br>Үгүй-2 | 0 | 1 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичгийн үйл ажиллагаа erp, DOCX токен цахим систем дээр бүрэн цахимжуулсан. Үүнд: Ирсэн явсан бичиг, өргөдөл гомдол, хүний нөөцийн үйл ажиллагаа, албан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчдын ирцийн бүртгэлүүд егр сүлжээнд бүрэн цахимжаад байна. Мөн байгууллагын даргын тоон гарын үсгийг баталгаажуулан суулгаж цахим албан бичиг явуулж байна. Байгууллагын албан хаагчид цахимаар өргөдөл гомдолоо хүлээн авч бүртгэн шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. 11 сарын 01-ны байдлаар тус байгууллагад иргэн, аж ахуй нэгж, албан хаагчдаас нийт 10-н өргөдөл гомдол ирснийг цахимд шивэн бүртгэлжүүлж 100% шийдвэрлэж хариуг хүргүүлсэн байна. Мөн ирсэн бичиг-245, явсан бичиг-247 байгааг 100% цахимаар солилцож бүртгэлжүүлсэн байна. | |
| Зорилт 9 | Мал аж ахуйн салбарт хяналт шалгалт хийх | Улсын төсөв-0,32 мян.төг | Хяналт шалгалт хийсэн тоо | 1 | 1 | Урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд 15 сумыг хамруулан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн дүн танилцуулгыг хугацаанд нь хүргүүлж ажилласан. | 100 |
| 9.1 | Өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангалт, мал аж ахуйн салбарын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналтыг хийх | | Хамрагдсан сумын тоо | - | 15 | Дээд газраас ирүүлсэн удирдамжийн хүрээнд аймгийн хэмжээний 15 суманд МАА-н өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд хяналт, шалгалтыг хийж удаашралтай болон хийж гүйцэтгээгүй 5 төрлийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймаг, сумдын удирдлагуудад улсын байцаагчийн хугацаатай зөвлөмжийг хүргүүлэн биелэлтийг тооцон ажиллаж байна. Мөн сумдын тасгийн мэргэжилтэн нарт малын бэлчээр сонгох, малд тэжээлийн хэрэгцээ шаардлагыг тооцоолох арга аргачлалын тухай сургалтын хичээл бэлтгэн өгч 3 сумын 615 малчид, иргэдэд мэдээллийг хүргэн ажилласан. Хяналт шалгалтын дүн танилцуулгыг гаргаж холбогдох дээд шатны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | улсын байцаагчид хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | |
| 9.2 | Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх ажил урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв-0,25 мян.төг | Хяналт шалгалтын тоо | 2 | 1 | Аймгийн хэмжээнд нийт 7 сумын 10 мян.га бэлчээрийн талбайд бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцсэн ажилд явцын хяналтыг хийж нийт 12 зөрчил дутагдал илрүүлж газар дээр нь 6 зөрчлийг арилгуулж, үлдсэн 6 дутагдлыг арилгуулахаар 1 сумын удирдлагад албан бичгээр үүрэг чиглэл өгч ажлыг сайжруулан гүйцэтгүүлсэн. Хяналт шалгалтын явцад УХЭШХүрээлэнгийн мэрэгч судлаачтай хамтран холбогдох 7 сумдын багийн Засаг дарга нар мэргэжилтэн нийт 45 иргэнд технологийн заавар зөвлөгөө өгч алдаа дутагдлыг газар дээр нь арилгуулсан. Сумдаас гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт өгч, хяналт шалгалтын дүн танилцуулгыг холбогдох дээд шатны байцаагчид хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | 100 |
| | | УТөсөв-0,19 мян.төг | Тухайн жилд тэмцсэн талбайн хэмжээ Мян/га | 29,5 | 30,0 | Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумдын 10,0 мянган га талбайд Микробиологийн аргаар,хээрийн техникийн үр дүн 83,7% хувьтай тэмцсэн. Энгийн механик аргаар 30 мянган га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулж байна. Энэ онд нийт 40,0 мян,га талбайд тэмцэх ажлыг зохион байгуулсан. | 100 |
| Зорилт 10 | Зорилтот жилийн хүрээнд малчид, иргэдийг чадавхижуулах | Төсөл хөтөлбөр, ОНТ- 19,8 сая.төг | Чадавхжуулсан иргэдийн тоо | 3457 | 1535 | Зорилтот жилийн хүрээнд 5 салбарын чиглэлээр 9 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан. Нийт 4794 малчид, иргэдийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, чадавхжуулахад төсөл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөрийн байгууллага, сумдын засаг даргын тамгын газар, малчид иргэдтэй хамтран ажилласан. | |
| 10.1 | Тариалан эрхлэгч нарт технологийн мэдлэг олгож чадавхижуулах | Төсөл хөтөлбөр, 14,5 сая, ОНТ-4,0 сая | Зохион байгуулсан сургалтын тоо | 1 | 5 | 1."Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Судалгаа хөгжлийн төв", Япон улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/ байгууллагатай хамтран төмс, хүнсний ногооны дэмжих “SHEP” хөтөлбөрийн хүрээнд “Хүнсний ногоог хэрхэн өргөжүүлэн хөгжүүлэх”, “Хөдөө аж аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх”, “Газар тариалангийн цахим систем бүртгэх”, урамшуулалд хамрагдах сэдэвт сургалтад 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Дундговь аймагт зохион байгууллаа. Уг сургалтад 13 сумын хүнсний ногооны тариалах сонирхолтой 60 тариалан эрхлэгч нар хамрагдсан байна. 2. “Алимын мод тарих сургалт”-ыг Политехник коллеж, БОАЖГ хамтран сургалтад хамрагдсан хүнсний ногооны үйлдвэрлэл, жимс жимсгэнэ, ойжуулалт,цэцэрлэгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч 140 хүн хамрагдсан байна. 3. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоолны үйлдвэрлэлийг дэмжих" төслийн нэгжтэй хамтран Сайнцагаан сумаас сонгогдсон “Мандал”, “Говийн Ирээдүй” сургуулийн үдийн хоолны хангамжид төмс, хүнсний ногоо нийлүүлэх 10 ногоочинд сонгож, хаврын тариалалтын зориулан нэн шаардлагатай үр болон гар багаж, хүлэмжийн тоног төхөөрөмжийг нийт 11.0 сая төгрөгийн үнэ бүхий багажийг | 100 |
| | | | Хамрагдсан иргэдийн тоо | 20 | 150 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүлээлгэн өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ногоочдын хүлээлгэн өгөв. Уг 10 ногоочинд төмс, хүнсний ногоо нийлүүлэх танхимын болон талбайн үзүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг ахмад агрономич Н.Цэнд-Аюуш, ногоочин Р.Мужил багш нар удирдан явуулж хамтран ажиллав. 4.“Каритас Монгол байгууллагын танилцуулга, газар тариалангийн төслийн ололт амжилт, үр дүн”, “Нарны эрчмээр ажиллах хүлэмжийн онцлог, ажиллуулах, арчлах”, "Байгал орчныг хамгаалахад хүний хүчин зүйлийн нөлөө " "Чийгийн улаан хорхой үржүүлэх, гэрийн нөхцөлд био ялзмаг бордоо гарган авах" сэдэвт сургалтад 2023 оны 3 дүгээр сарын 21-ний өдөр Дундговь аймагт зохион байгууллаа. Уг сургалтад төмс, хүнсний ногоо тариалах сонирхолтой 30 тариалан эрхлэгч хамрагдсан байна. 5. Санамж бичгийн хүрээнд Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, МОРА ТББ болон МОРА ЖИ ЭЙ групптэй хамтран “Хүнсний ногоо, хүлэмжийн бизнесийн ирээдүйн чиг хандлага, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх гарц – Япон орны туршлагаас” сэдэвт сургалтыг санал солилцох уулзалтыг есдүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон нийт 45 газар тариалан эрхлэгчдийн төлөөлөл оролцлоо. 5 удаагийн сургалтаар 285 иргэнийг хамруулсан сургалтыг үр дүнтэй зохион байгууллаа. Төслийн байгууллагаас нийт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 14,5 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. | |
| 10.2 | Мал үржлийн ажлын чанар хүртээмжийг сайжруулах | ОНТ-5,0 сая | Хамрагдсан малчдын тоо | 3236 | 1000 | 2023 оны 2, 5 саруудад Аймгийн Засаг даргын 15-н сумдын иргэдтэйгээ уулзах уулзалтын ажлын хэсэгт ажиллаж 2300 иргэд, малчдад мал аж ахуйн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн.<br>НҮБ-ын Хөдөө аж ахуйн байгууллагаас Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Дэлгэрхангай сумдын цөөн малтай 30-н малчин өрхөд мал аж ахуйн талаарх сургалтыг хийж тусламжийн эд зүйлсийг хүлээлгэн өгсөн.<br>Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг 15-н сумдын 545 малчидтай уулзаж хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгуулсан.<br>Мал аж ахуйн сэргэлт залуу малчдын үндэсний чуулганд 15-н сумын 35 -н залуу малчид оролцсон.<br>10 сарын 22 нд "Мал аж ахуйн салбарын эмэгтэйчүүд" 400 малчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохион байгуулсан.<br>Өлзийт, Говь-Угтаал Луус сумдын нийт 700 малчдын зөвлөгөөнд оролцож мал аж ахуйн чиглэл, бэлчээр, тэжээлийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэсэн. энэ онд 6-н арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор нийтдээ 4010 малчинд мэдээлэл хүргэж ажилласан. | 100 |
| 10.3 | Тэжээлийн ургамал тариалах иргэдийг арга зүй удирдлагаар хангах | | Хамрагдсан малчны тоо | 200 | 300 | Тэжээлийн ургамал тариалах, технологийн талаар 05 сарын 10 нд Говь-Угтаал сумын малчдын зөвлөгөөн болон малын тэжээлийн ургамал тариалах иргэд 250 хүнд, бэлчээрийн хортон мэргэчтэй тэмцэх, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ОНТ-5,0 сая | | | | хамгаалах чиглэлээр арга зүй зөвлөгөөг 7 сумын ХАА мэргэжилтэн, малчид, иргэд нийт 75 хүнд нийт 325 хүнд бэлчээр хамгаалах чиглэлийн мэдээллийг хүргэж арга зүй удирдлагаар ханган ажилласан. | |
| 10.4 | Үйлдэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд үйлдвэрийн зохистой дадал GMP, эрүүл ахуйн зохистой дадал GHP, хоолны газрын эрүүл ахуй болон, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавигдах шаардлага MNS4946:2019 стандартын мэдлэг олж авахад дэмжлэг үзүүлэх | ОНТ-0,01 сая.төг Хувийн хэвшил-1,4 сая | Сургалтад хамрагдсан иргэдийн тоо | - | 25 | Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, "Фүүд Трэйнинг Консалтинг" сургалтын төв хамтран, зоогийн газар, кафе, цайны газрын нийт 25 тогооч нарыг 5 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд сургалтад хамруууллаа.<br>Сургалтаар Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавигдах шаардлага MNS4946:2019 стандарт, "Технологийн карт мөрдөх" журам, "Хүнсний ногооны хорогдлын норм тооцох аргачлал", "Хоолны шим тэжээлийн үзүүлэлт, Илчлэг тооцох аргачлал" "Хоолны газрын эрүүл ахуй", GMP- Үйлдвэрлэлийн зохистой дадал", "GHP-Эрүүл ахуйн зохистой дадал" сэдэвт нийт 16 цагийн хичээлийг онол дадлага хослуулан зохион байгуулсан. Стандарт хэмжил зүйн хэлтсийн Сорилтын итгэмжлэгдсэн лабораторийн үйл ажиллагаатай суралцагчдыг танилцуулсан. | 100 |
| 10.5 | "Хүнсний бүтээгдэхүүний хаяг, шошго" сэдэвт сургалтыг зохион байгуулах | ОНТ-0,01сая.төг | Аж ахуй нэгж, иргэдийн тоо | - | 30 | Адаацаг сумын малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөнд оролцогч 149 иргэнд Хүнсний бүтээгдэхүүний хаяг, шошго сэдэвт сургалтыг хүнс, хоол үйлдвэрлэлийн хяналтын улсын байцаагч нар зохион байгуулсан. | 100 |
| 10.6 | Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа шинээр эрхлэгчидэд www.igov.mn | | Цахим системд бүртгэгдсэн иргэн | 213 | 6 | Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа шинээр эрхлэгч 1, аж ахуй нэгжийн эзэмшигч өөрчлөгдсөн 8 газарт www.igov.mn цахим | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахим системийг таниулж, иргэн аж ахуй нэгжийг бүртгэлжүүлэх. | 0 | аж ахуй нэгжийн тоо | | | системийг таниулж, мэдээллийг шинээр болон, шинэчлэн бүртгэлжүүлж ажилласан. | |
| 10.7 | Хүнсний зориулалттай хуванцар савны тэмдэг,тэмдэглэгээний талаар мэдээлэл хүргэх | ОНТ-0,1 сая.төг | Аж ахуй нэгж, иргэдийн тоо | - | 30 | Адаацаг сумын малчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөнд оролцогч 149 иргэнд Хүнсний зориулалттай хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээ, хэрэглээний талаар сургалт хийсэн. | 100 |
| Зорилтын биелэлтийн хувь /19/ | | | | | | | 100 |
| Арга хэмжээний биелэлтийн хувь /63/ | | | | | | | 98,7 |
| Биелэлтийн хувь | | | | | | | 99,3 |

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХЖАРГАЛ

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(гарын үсгийн тайлал)*

ХЭРЭГЖИЛТИЙГ ТООЦСОН:

ЗАХИРГАА АЖ АХУЙ АЛБАНЫ ДАРГА Ж.ШИНЭ-УЯНГА

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(гарын үсгийн тайлал)*